

УЗДан 1993 оон 282р захиргааг хүчингүй

68



**Б Н М А У**  
**УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН**  
**ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1991 оны 01 сарын 24

№ 33.

Улаанбаатар хот

Шашны сургалттай дунд сургууль байгуулах тухай

Улаанбаатар хотын Ардын Хурлын Гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

1. Шашны сургалттай дунд сургуулийг 1991 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хотын боловсролын газарт харьяалуулан байгуулсугай.

*УЗД 93 А/103 Захиргааг*

2. Шашны сургалттай дунд сургуулийн дүрмийг нэгдүгээр хавсралт ёсоор баталсугай.

3. Шашны сургалттай дунд сургуулийн сургалт хүмүүжлийн зардлыг төсвөөс санхүүжүүлэхийг Хотын санхүүгийн газар /н.ЮНГОР/-т цаалгасугай.

4. Багшлах боловсон хүчнээр хангаж, сургалт хүмүүжлийн ажилд арга зүйн туслалцаа үзүүлж байхыг Хотын боловсролын газар /н.Чимэддорж/-т цаалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА -?

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА 2.

*[Handwritten signature]*

Л.ЭНЭБИШ

Ч.СУМААХҮҮ

69

Улаанбаатар хотын Ардын Хурлын  
гүйцэтгэх захиргааны 1991 оны  
33 дугаар тогтоолын хавсралт

ШАШНЫ СУРГАЛТЫН ДУНД СУРГУУЛИЙН  
ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Шашны сургуулийн үндсэн зорилт нь суралцагчдад ертөнцийг үзэх шашны буюу шинжлэх ухааны мэдлэг олгох, өөрийн болон бусад орны шашны зан үйл уламжлал, түүх, гүн ухааны соёлын өвөөс суралцах, бие бялдар, хувь хүний хүмүүжлийг төлөвшүүлэх, хүнлэг энэрэнгүй ёс суртахуунаар хүмүүжүүлэхийг гол зорилт болгоно.

2. БНМАУ-ын Боловсролын хуулийг үндэслэн сургалт, хүмүүжлийн ажлыг шашны зан үйлтэй хослон явуулна.

3. Сургууль хуулийн этгээд бөгөөд зохих журмын цагуу хийсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Сургалт, хүмүүжлийн ажлын зохион байгуулалт

1. Шашны сургалтыг бага, дунд үе шаттай зохион байгуулж, хүүхдийн нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон мэдлэг олгоно.

-Тус сургууль төгсөгчид нь шашны дээд сургууль, мамба, зурхай зэрэг таван ухааны хийд дугануудад дамжин суралцана.

-Сургалтын төлөвлөгөөний бүтэц нь шашны сургалтыг 60-аас доошгүй хувьд, ерөнхий эрдмийг 40 орчим хувьд оруулан заана.

-Сургалт хүмүүжлийг зохион байгуулах арга хэлбэр, жаяг дэглэмийг багш өөрөө тодорхойлно. Сургууль, хичээлийн цаг, завсарлах хугацааг тогтоож хичээлийн завсарлагаа, сургуулийн амралтыг сургуулийн онцлогт тохируулж өөрөө зохион байгуулна.

-Хүүхдийн авъяас чадварын түвшинд хяналт тавьж, анги алгасуулах, дэвшүүлэх, улируулах асууцлыг бие дааж шийднэ.

-Сургуулийн дүрмийг ноцтой зөрчсөн, сурлага, сахилга бат, сахил санваар, жаяг дэглэмийг зөрчсөн шавь нарыг сургуулиас хөөх хүртэл арга хэмжээ авна.

-Шашны бага, дунд сургууль төгссөн үед нь шашны дээд сургуулиас шалгаж үнэмлэх олгоно.

-Сургуулийн дэргэд сургалт хүмүүжлийн ажилд туслах зорилгоор сургуулийн зөвлөл байгуулан ажиллуулна. Тус зөвлөл сургуулийн дүрмийг биелүүлж, хэрэгжилтэнд хяналт тавина.

Лам шавь нарыг элсүүлэн авах журмыг сургуулийн зөвлөл шийдвэрлэнэ.

-Багш нарыг ажиллуулах, тэдний ажлыг урамшуулах, халах, солих асуудлыг сургуулийн зөвлөл шийднэ. Шийдвэрийг холбогдох дээд байгууллагад танилцуулна.

-Сургалтын төлөвлөгөөг сургуулийн зөвлөл боловсруулж, Боловсролын яам, шашны төвөөр батлуулна.

-Багш ажиллуулах журмыг сургуулийн зөвлөл шийдвэрлэх ба тодорхой хугацаанд гэрээгээр ажиллуулна.

-Сургуулийн зөвлөл нь сургуулийн удирдлагын ажил үүргийг тогтоож, тэднийг томилох, халах, тушаал бууруулах, цалингийн урамшууллыг шийдвэрлэх эрхтэй.

-Бусад өр улс орны шашны төвүүдтэй хамтран ажиллаж багш, шавь нарыг солилцох асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлнэ.

-Сургуулийн лам, шавь нарын уншлагыг батжуулах зорилгоор сүм дуганд уншлага хийлгэх, өөрсдөө бие даан цогчин, хурлын уншлагыг уншиж дадах.

-Шашны зан үйл, хурал ном, хүрээ хийдтэй танилцуулах дадлагыг төлөвлөгөөтэй зохион байгуулна.

Турав. Сургуулийн удирдлагын гүйцэтгэх үүрэг

-Сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг захирал удирдан зохион байгуулна.

-Сургуулийн зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион явуулна.

-Сургалт хүмүүжлийн ажилд хяналт тавьж эвсэг бүтээлч хамт олон бий болгон сургалтын ажлын чанар дунг улсын болон хамт олны өмнө хариуцна.

-Сургуулийн нэрийн өмнөөс бусад байгууллагатай харилцан гэрээ байгуулж хөрөнгө мөнгө захиран зарцуулж банкинд харилцах данс нээх эрх эдэлнэ.

-Багш сурган хүмүүжүүлэгчдийг ажил дээр нь сургах арга барил эзэмшүүлэх ажлыг зохион байгуулна.

3.

-Багш, эцэг эх, шавь нарын санал хүсэлтийг сонсож, шаардагдах арга хэмжээ авч хамт олны өмнө ажлаа тайлагнана.

-Сургууль хөгжүүлэх хэтийн чиглэлийг тодорхойлох, түүний материаллаг баазыг бэхжүүлэх, сургалт хүмүүжлийн арга барилыг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх ажлыг шийцвэрлэнэ.

-Сургуулийн эцэг эхийн хороо, анги бүрт эцэг эхийн зөвлөл ажиллах бөгөөд түүний үйл ажиллагааг АБЯ-наас баталсан дүрмээр зохицуулна.

Дөрөв. Сургуулийн санхүү, материаллаг бааз

-Сургууль нь лам шавийн тоо, эдийн засгийн норм, норматив, лимитийг үндэслэн ганцаарчилсан төсөв зохиож хамт олноор хэлэлцүүлсний үндсэн дээр баталж мөрдөнө:

-Сургууль нь захиргааны болон багш, үйлчлэх ажилчдын тоог ерөнхий боловсролын сургуулийн ажилтнуудын цалингийн жишгийг баримтлан тогтвортой мөрдөх, цалингийн Фондоо баталж тогтооно.

-Сургуулийн захиргаа нь улирал, жилийн тайлан балансад эдийн засгийн шинжилгээ хийж дүнг сургуулийн хөдөлмөрийн хамт олноор хэлэлцүүлэн зохих арга хэмжээ авч байхын хамт тайлан балансыг холбогдох санхүүгийн байгууллагад тушааж тооцоо хийж байна.